



АМГАЛАН АМАРЖИХ ГАЗАР
ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛГИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/120

Улаанбаатар хот

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг,
шинжилгээ, оношилгоо зохион байгуулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.24 дэх заалт, Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоол, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоол, Эрүүл Мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаал, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 06 дугаар тогтоол, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны А/77 дугаар тушаал, амаржих газрын дүрмийн 5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагаа 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс орон даяар эхлэхтэй холбоотой амаржих газарт “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах журмыг хоёрдугаар, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгооны ерөнхий зураглалыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг байгуулах, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог хугацаанд нь эхлүүлэхтэй холбоотой гарах зардлыг хууль журмыг дагуу холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Дангаа/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын ажилтан /Ө.Сүрнээ/-д даалгасугай.

ЗАХИРАЛ

Ц.БАТБОЛД

